



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/303

Улаанбаатар хот

Тэсэлгээний ажил, мэргэжлийн үнэмлэх
олгох сургалтын тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор баталсан “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн 32 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Тэсэлгээний ажил, мэргэжлийн үнэмлэх олгох сургалтыг зохион байгуулах зааврыг нэгдүгээр, үнэмлэх олгох, сунгах, хүчингүй болгох шаардлагыг хоёрдугаар, тэсэлгээний ажил, мэргэжлийн үнэмлэхний загварыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


2.Тэсэлгээний ажил, мэргэжлийн үнэмлэх олгох сургалтыг холбогдох хууль, дүрмийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэлгүй, шуурхай зохион байгуулж байхыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв /Л.Пүрэв/-д зөвлөсүгэй.

3.Тэсэлгээний ажил, мэргэжлийн үнэмлэх олгох сургалтыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, бодлогын удирдамжаар хангаж, сургалтын хөтөлбөрийг баталж ажиллахыг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл /М.Мэндбаяр/-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Уул уурхайн сайдын 2014 оны 70 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Баасанпүрэв/-т даалгасугай.

САЙД  Ж.ГАНБААТАР



1508 01 0742

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2023 оны 10... дугаар сарын 02...-ний
өдрийн 1/303 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

1. Сургалтыг зохион байгуулах үндсэн чиглэл

1.1. Сургалтын зорилго нь ажилтанд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг тухай бүр богино хугацаанд эзэмшүүлэх, тэсэлгээний аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн мэдлэгийг олгоход оршино.

1.2. Сургалтад үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, тусгай зөвшөөрөл шинээр авахаар холбогдох материал бүрдүүлж байгаа болон тусгай зөвшөөрөлтэй байгууллагаас мэргэжлийн туслалцаа авч байгаа захиалагч, гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс Сургалтын байгууллагад ирүүлсэн хүсэлтийн дагуу хамрагдана.

1.3. Сургалтад хамрагдах удирдагч, тэсэлгээчинд тавигдах нөхцөл, шаардлагыг Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 13, 16, 17, 18, 19 дэх заалтуудыг, тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцах ажилтан бэлтгэх сургалтад бүрэн бус дундаас доошгүй боловсролтой, 18-аас дээш насны Монгол Улсын иргэнийг тус тус хамруулна.

1.4. Уул уурхайн салбарт 15 болон түүнээс дээш жил ажилласан салбарын мэргэшсэн, зөвлөх инженерийн зэрэгтэй уул уурхайн ашиглалтын технологийн инженерийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолтыг үндэслэн Тэсэлгээний ажлын удирдагчийн сургалтад шууд хамруулж болно.

1.5. Сургалтын хөтөлбөрүүд нь дараах төрөлтэй байх бөгөөд Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 33 дугаар зүйлд заасны дагуу Мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан байна. Үүнд:

1.5.1. Тэсэлгээний ажлын удирдагч болон хариуцлагатай удирдагч бэлтгэх сургалтын хөтөлбөр;

1.5.2. Тэсэлгээчин бэлтгэх сургалтын хөтөлбөр;

1.5.3. Тэсэлгээний туслах ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөр;

1.5.4. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөр;

1.5.5. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолоочийн сургалтын хөтөлбөр;

1.5.6. Үйл ажиллагааныхаа чиглэлээр тэсрэх материал ашиглахтай холбоотой ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөр.

1.6. Сургалтын хөтөлбөр нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд оролцогч иргэнд холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт, техник

технологийн горим, тэсрэх материалын ашиглалт зарцуулалтын чиглэлээр тусгайлан боловсруулсан, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих чиг үүрэгтэй Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл/ цаашид “Мэргэжлийн зөвлөл” гэх/-өөр батлуулсан хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдана.

1.7. Тэсэлгээний ажлын удирдагч болон хариуцлагатай удирдагч, тэсэлгээчин, тэсэлгээний туслах ажилтан бэлтгэх, үйлдвэрийн ажилтан бэлтгэх эрх олгох сургалтын үргэлжлэх хугацаа 40 цаг, Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолоочийн сургалтын үргэлжлэх хугацаа 24 цаг, Үйл ажиллагааныхаа чиглэлээр тэсрэх материал ашиглахтай холбоотой ажилтан бэлтгэх сургалтын үргэлжлэх хугацаа 16 цаг, эрх сунгах сургалтын үргэлжлэх хугацаа 8 цаг байх ба ажилтан нь сургалтын агуулгыг бүрэн хангаж оролцсоноор шалгалтад хамрагдах эрхтэй болно.

1.8. Сургалтын байгууллага нь сургалтын хуваарь, сургалттай холбоотой мэдээллийг өөрийн веб хуудас болон цахим сүлжээгээр аж ахуйн нэгжүүдэд ил тод, шуурхай мэдээлэл өгч байна.

1.9. 1.5.1-1.5.6-д заасан хөтөлбөрийн эрх олгох сургалтуудыг нэг улиралд тус бүр 1-ээс доошгүй удаа зохион байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд Мэргэжлийн комиссын шийдвэрээр сургалтыг цахимаар явуулж, шалгалтыг тусгайлан боловсруулсан програмаар авч болно.

1.10. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 35 дугаар зүйлд заасан байгууллага нь энэ зааврын 1.5.6-д заасан сургалтыг зохион байгуулж болох бөгөөд сургалтад хамрагдсан тухай нотлох бичиг баримтын хамт энэ зааврын 1.12-д заасан Мэргэжлийн комисс шалгалт авч, тэнцсэн тохиолдолд эрхийн үнэмлэхийг олгоно.

1.11. Сургалттай холбоотой мэдээллийг Засгийн газрын 2023 оны 406 дугаар тогтоолоор батлагдсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журам”-ын 3.2.2-т заасны дагуу хүргүүлнэ.

1.12. Сургалтын байгууллага нь тухайн жилийн сургалтын тайланг Мэргэжлийн зөвлөлд тайлагнана.

1.13. Тэсэлгээний ажлын удирдагч, тэсэлгээчин, тэсэлгээний ажил, тэсрэх материалтай харьцах эрх олгох, сунгах сургалтыг зохион байгуулах мэргэжлийн комиссыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилно. Мэргэжлийн комисс нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

1.13.1. Комиссын дарга: (Сургалтын байгууллагын захирал);

1.13.2. Гишүүд: (Салбарын хяналтын газрын улсын байцаагч, сургалтын байгууллагын сургалт хариуцсан албан тушаалтан).

УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ГАЗАР

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2023 оны 10 дугаар сарын 02-ний
өдрийн А/303 дугаар тушаалын
хоёрдугаар дугаар хавсралт

ҮНЭМЛЭХ ОЛГОХ, СУНГАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ШААРДЛАГА

1.1. Сургалтын агуулгыг бүрэн хангаж оролцсон, Мэргэжлийн комиссын шалгалтад тэнцсэн ажилтанд сургалтын хөтөлбөрийн дагуу эрх олгоно.

1.2. Мэргэжлийн комиссын шалгалтад тэнцсэн ажилтанд үнэмлэх олгохдоо эрх олгосон, хугацаа сунгасан тухай протоколыг үйлдэн, Мэргэжлийн комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, сургалтын байгууллага болон улсын байцаагчийн тэмдгээр баталгаажуулна. Үнэмлэхийг хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид 14 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

1.3. Мэргэжлийн комисс нь батлагдсан хөтөлбөрийн хичээлийн агуулгаас 30-40 асуултыг санамсаргүй байдлаар түүвэрлэн бэлтгэж шалгалтыг авах ба 70 хувиас дээш оноо авсан ажилтныг шалгалтад тэнцүүлнэ.

1.4. Мэргэжлийн комиссын шалгалтад тэнцээгүй тохиолдолд тухайн ажилтны хүсэлтээр дахин 2 удаа шалгалтыг төлбөргүй авч болно. Давтан шалгалтыг үндсэн сургалтад хамрагдсанаас хойш 1 сарын дотор өгсөн байна. Ажилтан 3 дахь удаагийн шалгалтад тэнцээгүй тохиолдолд дахин сургалтад хамрагдаж болох ба байгууллагын албан хүсэлтийг үндэслэн шинээр үнэмлэх олгох сургалтад бүртгэж хамруулна.

1.5. “Тэсэлгээний ажлыг удирдах эрхийн үнэмлэх” нь улаан өнгийн дэвсгэр бүхий суурь дээр тэсэлгээний процессыг харуулсан логотой, “Тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхийн үнэмлэх” нь хөх өнгийн дэвсгэр бүхий суурь дээр тэсэлгээний процессыг харуулсан логотой, “Тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэх” нь ногоон өнгийн дэвсгэр бүхий суурь дээр тэсэлгээний процессыг харуулсан логотой пластик бэлдэц дээр хэвлэгдсэн, QR кодоор нууцлагдсан, анхааруулах талонтой, хүчинтэй хугацааг харуулсан байна. Үнэмлэхийн загварыг гуравдугаар хавсралтаар үзүүлэв.

1.6. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 14 дэх заалтын дагуу далд уурхайн нэмэлт хөтөлбөрөөр сургалтад хамрагдсан ажилтны “Тэсэлгээний ажлыг удирдах эрхийн үнэмлэх”-д “далд уурхайд ажиллах” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийнэ.

1.7. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 20 дахь заалтын дагуу тусгай тэсэлгээний ажлын хөтөлбөрөөр сургалтад хамрагдсан ажилтны “Тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхийн үнэмлэх”-д тухайн төрлөөр тэсэлгээний ажил гүйцэтгэнэ гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийнэ.

1.8. Тэсэлгээний ажлыг удирдах, тэсэлгээний ажил гүйцэтгэх, тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэхийн бүртгэлийн дугаар нь тухайн үнэмлэхийг анх олгосон он, ажилтны хувийн дугаараас бүрдэнэ. Жишээ нь: № 23/001 бүртгэлийн дугаарлалтын “23” нь 2023 он, “001” ажилтны хувийн дугаар байна.

1.9. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 43 дахь заалтыг зөрчсөн ажилтны үнэмлэхийг гэмт хэргийн шинжгүй бол 12 сарын хугацаатай хүчингүй болгосон тухай протоколыг үйлдэн үнэмлэхийг хурааж Мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд тэмдэглэн устгана.

1.10. Үнэмлэхийг гээгдүүлсэн тохиолдолд байгууллагын албан хүсэлт, гээгдүүлсэн тухай өдөр тутмын сонинд зарлуулсан баримтыг үндэслэн нөхөн олгоно. Дугаарыг үрэгдүүлсэн үнэмлэхийн дугаараар дугаарлах ба нөхөн олгов гэсэн тэмдэглэл хийнэ.

1.11. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн 22 дахь заалтын дагуу сургалт зохион байгуулсан байгууллага нь шалгалтын материал, комиссын протокол, бусад баримт бичгийг хөтөлж хадгална.

1.12. Сургалтад сууж тэнцсэн ажилтны үнэмлэхийг үнэгүй хэвлэж олгох бөгөөд хэрэв ажилтан нь нэг байгууллагаас өөр байгууллагад шилжих, үрэгдүүлсэн тохиолдолд үнэмлэх хэвлэх зардлыг төлүүлнэ.

1.13. Үнэмлэхийн хугацаа нь олгосон өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Үнэмлэхийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө байгууллагын албан хүсэлтээр сургалтын байгууллагад мэдэгдэж, давтан сургалтад хамрагдаж, шалгалт өгч, үнэмлэхийн сунгалт хийлгэнэ.

1.14. Үнэмлэхийн сунгалтыг хугацаанд нь хийлгээгүй, үнэмлэх нь хүчингүй болсон ажилтныг байгууллагын тодорхойлолт, нийгмийн даатгал шимтгэл төлөлтийг үндэслэн тухайн эрх олгох сургалтад хамруулж болно.

1.15. Давагдашгүй хүчин зүйлээс хамаарч давтан сургалтад хамрагдаагүй, үнэмлэхийн сунгалт хийлгэх хугацаа хойшлогдсон бол үнэмлэхийн сунгалтыг үнэмлэх олгосон өдрөөс эхлэн хүчинтэйд тооцно.


1.16. Хүндэтгэн үзэх шалтгаанаар үнэмлэхээ сунгуулаагүй бол байгууллагын тодорхойлолтыг үндэслэн сунгуулах хүсэлтийг нь Мэргэжлийн комисс хүлээн авч шийдвэрлэнэ.

1.17. Үнэмлэхтэй ажилтныг үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах тусгай зөвшөөрөлтэй эсэхээс үл хамааран ажилтны өөрийн хүсэлт, шилжүүлэн авч байгаа байгууллагуудын хүчин төгөлдөр тушаал, шийдвэрийн дагуу шилжүүлж болно.




1.18. Ажилтан өөр байгууллагад шилжихэд үнэмлэхэд заасан ажлыг гүйцэтгэх эрх нь хадгалагдана.

УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ГАЗАР


Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2023 оны 10 дугаар сарын 02-ний
өдрийн А/303 дугаар тушаалын
гуравдугаар дугаар хавсралт



ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

 <p>Тэсэлгээний ажлыг удирдах эрхийн ҮНЭМЛЭХ</p>	<p>Үнэмлэх № 23/001</p>  <p>Овог: Дугар Нэр: Дондог Байгууллага: Монгол ХХК Нөхцөл: Уурхайн нөхцөл Нэмэлт эрх: Далд уурхайн нөхцөл</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p> 	<p>Ажилтны мэдээлэл</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Регистрийн дугаар: УБ20010101 Байгууллага: Монгол ХХК Албан тушаал: Тэсэлгээний ажлын удирдагч Үнэмлэх: № 23/001 Нөхцөл: Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил удирдан гүйцэтгэх эрхтэй Сургалтанд хамрагдсан огноо: 2023.01.31</p> <p>Нэмэлт эрх: Далд уурхайн нөхцөл Нэмэлт эрх авсан огноо: 2023.02.28</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p> <p>ШУТИС-ийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв, УУХУЯамны Салбарын хяналтын газрын дэргэдэх Мэргэжлийн комиссын 2023 оны 01-р сарын 31 өдрийн 02/2023 дугаар протоколыг үндэслэн 2023 оны 01 сарын 31 өдөр олгов.</p> <p>Мэргэжлийн комиссын дарга: Тамга _____ Гишүүд _____</p>
---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Загвар 1. Тэсэлгээний ажлыг удирдах эрхийн үнэмлэхийн хоёр тал, QR кодонд агуулагдах ажилтны мэдээлэл

 <p>Тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхийн ҮНЭМЛЭХ</p>	<p>Үнэмлэх № 23/001</p>  <p>Овог: Дугар Нэр: Дондог Байгууллага: Монгол ХХК Нөхцөл: Уурхайн нөхцөл</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p> 	<p>Ажилтны мэдээлэл</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Регистрийн дугаар: УБ20010101 Байгууллага: Монгол ХХК Албан тушаал: Тэсэлгээчин Үнэмлэх: № 23/001 Нөхцөл: Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхтэй Сургалтанд хамрагдсан огноо: 2023.01.31</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p> <p>ШУТИС-ийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв, УУХУЯамны Салбарын хяналтын газрын дэргэдэх Мэргэжлийн комиссын 2023 оны 01-р сарын 31 өдрийн 02/2023 дугаар протоколыг үндэслэн 2023 оны 01 сарын 31 өдөр олгов.</p> <p>Мэргэжлийн комиссын дарга: Тамга _____ Гишүүд _____</p>
-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Загвар 2. Тэсэлгээний ажил гүйцэтгэх эрхийн үнэмлэхийн хоёр тал, QR кодонд агуулагдах ажилтны мэдээлэл

	<p>Үнэмлэх № 23/001</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Байгууллага: Монгол ХХК Нөхцөл: Уурхайн нөхцөл</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p>	<p>Ажилтны мэдээлэл</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Регистрийн дугаар: УБ20010101 Байгууллага: Монгол ХХК Албан тушаал: Тэсэлгээчний туслах ажилтан Үнэмлэх: № 23/001 Нөхцөл: Уурхайн нөхцөлд тэсэлгээний ажилд туслан гүйцэтгэх эрхтэй Сургалтанд хамрагдсан огноо: 2023.01.31</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p> <p>ШУТИС-ийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв, УУХУЯамны Салбарын хяналтын газрын дэргэдэх Мэргэжлийн комиссын 2023 оны 01-р сарын 31 өдрийн 02/2023 дугаар протоколыг үндэслэн 2023 оны 01 сарын 31 өдөр олгов.</p> <p>Тамга Мэргэжлийн комиссын дарга: Гишүүд:</p>

Загвар 3. Тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэхийн хоёр тал, QR кодонд агуулагдах ажилтны мэдээлэл /тэсэлгээний туслах ажилтан/

	<p>Үнэмлэх № 23/001</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Байгууллага: Монгол ХХК Нөхцөл: Үйлдвэрийн нөхцөл</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p>	<p>Ажилтны мэдээлэл</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Регистрийн дугаар: УБ20010101 Байгууллага: Монгол ХХК Албан тушаал: Химич Үнэмлэх: № 23/001 Нөхцөл: Үйлдвэрийн нөхцөлд ажиллах эрхтэй Сургалтанд хамрагдсан огноо: 2023.01.31</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p> <p>ШУТИС-ийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв, УУХУЯамны Салбарын хяналтын газрын дэргэдэх Мэргэжлийн комиссын 2023 оны 01-р сарын 31 өдрийн 02/2023 дугаар протоколыг үндэслэн 2023 оны 01 сарын 31 өдөр олгов.</p> <p>Тамга Мэргэжлийн комиссын дарга: Гишүүд:</p>

Загвар 4. Тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэхийн хоёр тал, QR кодонд агуулагдах ажилтны мэдээлэл /үйлдвэрийн ажилтан/

	<p>Үнэмлэх № 23/001</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Байгууллага: Монгол ХХК Нөхцөл: Тээврийн нөхцөл</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p>	<p>Ажилтны мэдээлэл</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Регистрийн дугаар: УБ20010101 Байгууллага: Монгол ХХК Албан тушаал: Жолооч Үнэмлэх: № 23/001 Нөхцөл: Тэсрэх материал тээвэрлэх тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй Сургалтанд хамрагдсан огноо: 2023.01.31</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p> <p>ШУТИС-ийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв, УУХУЯамны Салбарын хяналтын газрын дэргэдэх Мэргэжлийн комиссын 2023 оны 01-р сарын 31 өдрийн 02/2023 дугаар протоколыг үндэслэн 2023 оны 01 сарын 31 өдөр олгов.</p> <p>Мэргэжлийн комиссын дарга: Тамга _____ Гишүүд _____</p>

Загвар 5. Тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэхийн хоёр тал, QR кодонд агуулагдах ажилтны мэдээлэл /тээврийн нөхцөл - жолооч/

	<p>Үнэмлэх № 23/001</p> <p>Овог: ДУГАР Нэр: ДОНДОГ Байгууллага: МОНГОЛ ХХК Нөхцөл: ТЭСРЭХ МАТЕРИАЛТАЙ ОРЧИНД АЖИЛЛАХ</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p>	<p>Ажилтны мэдээлэл</p> <p>Овог: Дугар Нэр: Дондог Регистрийн дугаар: УБ20010101 Байгууллага: Монгол ХХК Албан тушаал: ХАБЭА-н инженер Үнэмлэх: № 23/001 Нөхцөл: Тэсрэх материалтай шууд харьцахгүй зөвхөн тэсрэх материалтай орчинд ажиллах эрхтэй. Сургалтанд хамрагдсан огноо: 2023.01.31</p> <p>Хүчинтэй хугацаа: 2025.01.31</p> <p>ШУТИС-ийн Тэсэлгээний сургалт, судалгааны төв, УУХУЯамны Салбарын хяналтын газрын дэргэдэх Мэргэжлийн комиссын 2023 оны 01-р сарын 31 өдрийн 02/2023 дугаар протоколыг үндэслэн 2023 оны 01 сарын 31 өдөр олгов.</p> <p>Мэргэжлийн комиссын дарга: Тамга _____ Гишүүд _____</p>

Загвар 6. Тэсрэх материалтай харьцах эрхийн үнэмлэхийн хоёр тал, QR кодонд агуулагдах ажилтны мэдээлэл /тэсрэх материалтай орчинд үйл ажиллагааныхаа чиглэлээр тэсрэх материал ашиглахтай холбоотой ажилтан/

УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ГАЗАР